



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Г

МУИС-ийн дүрмийн 5.1.3, 5.3.8.3 дахь заалт, МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.6, 2.8.6, 6.7 дахь хэсэг, Эрдмийн зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “МУИС-ийн профессор багшийн албан тушаалын зэрэглэл ахиулах, ажлын гүйцэтгэлийг тооцох журам”-ыг 1 дүгээр хавсралтаар баталж, 2024 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс дагаж мөрдсүгэй.

2. “МУИС-ийн профессор, дэд профессор цол олгох журам”-ыг 2 дугаар хавсралтаар баталж, 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

3. Тогтоол батлагдсантай холбогдуулан МУИС-ийн захирлын 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/208 дугаар тушаалаар батлагдсан “МУИС-д профессор багш ажиллуулах журам”-ын МУИС-ийн профессор, дэд профессор цол олгох тухай арван тавдугаар бүлгийг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөр, бусад бүлэг, хавсралтыг 2024 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөр, 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/412 дугаар тушаалаар батлагдсан “МУИС-д профессор багш ажиллуулах журам”-д оруулсан өөрчлөлтийг 2024 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөр тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. “МУИС-ийн профессор багшийн албан тушаалын зэрэглэл ахиулах, ажлын гүйцэтгэлийг тооцох журам”, “МУИС-ийн профессор, дэд профессор цол олгох журам”-ыг баталсантай холбогдуулан тус журмыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх удирдамж боловсруулан батлахыг МУИС-ийн ректор (Д.Бадарч)-д үүрэг болгосугай.

5. “МУИС-ийн профессор багшийн албан тушаалын зэрэглэл ахиулах, ажлын гүйцэтгэлийг тооцох журам”, “МУИС-ийн профессор, дэд профессор цол олгох журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг МУИС-ийн ректор (Д.Бадарч)-д үүрэг болгосугай.

ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА




Д.БАДАРЧ

Б.ДАВААСҮРЭН

1424030003

МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны 04 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт



МУИС-ИЙН ПРОФЕССОР, ДЭД ПРОФЕССОР ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Дээд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, МУИС-ийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, МУИС-ийн профессор багшийн албан тушаалын зэрэглэл ахиулах, ажлын гүйцэтгэлийг тооцох журамд нийцүүлэн МУИС-д профессор, дэд профессор цол олгох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. МУИС-ийн профессор, дэд профессор цол олгоход өндөр хөгжилтэй орнуудад баримталдаг түгээмэл шалгуур үзүүлэлт, хугацаат үнэлгээний систем (tenure track system)-ийн үндсэн зарчмыг жишиг болгоно.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

- 2.1. Энэхүү журамд холбогдох нэр томъёог “МУИС-ийн профессор багшийн зэрэглэл ахиулах, ажлын гүйцэтгэлийг тооцох журам”-д заасан тодорхойлолтоор ойлгоно.

Гурав. Профессор, дэд профессор цолны шалгаруулалт

- 3.1. МУИС-ийн профессор, дэд профессор цол олгох шалгаруулалтыг тухайн хичээлийн жилийн эхэнд (9 дүгээр сарын 30-ны дотор) явуулна.
- 3.2. МУИС-ийн профессор, дэд профессор цолд нэр дэвшигч эрдэм шинжилгээ, сургалт болон сургууль, нийгэмд үзүүлсэн үйлчилгээний чиглэлээр Хавсралт 1-д заасан оноог авсан байх шаардлагатай.
- 3.3. Тухайн чиглэлийн Web of Science JCR импакт фактораар эхний 5-д багтах мэргэжлийн сэтгүүлд МУИС-ийн нэрээр нэгдүгээр эсвэл холбоо барих зохиогчоор 1 өгүүлэл хэвлүүлсэн тохиолдолд эрдэм шинжилгээний үзүүлэлт бүрэн биелсэнд тооцно.
- 3.4. Инженер, математик, нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбарын судалгааны оноонд Web of Science JCR импакт фактор, Scopus CiteScore индекс бүхий мэдээллийн санд бүртгэгдсэн олон улсын эрдэм шинжилгээний хурлын бүрэн эмхэтгэлд хэвлүүлсэн илтгэл, МУИС-ийн нэрээр бүртгүүлсэн патент, захиалгат судалгаа, технологи дамжуулалтын нийлбэр оноог судалгааны онооны 30 хувь хүртэл хүлээн зөвшөөрч болно. Энэ тохиолдолд Web of Science JCR импакт фактор, Scopus CiteScore индекс бүхий олон улсын эрдэм шинжилгээний хурлын бүрэн эмхэтгэлд хэвлүүлсэн илтгэлд өгөх оноог олон улсын мэдээллийн сангийн бүртгэлд орсон мэргэжлийн холбоо, нийгэмлэг, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаас эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлийн өгүүлэлтэй дүйцүүлэн тооцно.
- 3.5. МУИС-ийн профессор цолд нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна:
 - 3.5.1. Дэд профессор цолтой байх
 - 3.5.2. 2-оос доошгүй докторант удирдаж хамгаалуулсан эсвэл 1 докторант удирдаж хамгаалуулсан бөгөөд профессор цолны эрдэм шинжилгээний оноог 2 дахин ба түүнээс дээш давуулан биелүүлсэн байх
 - 3.5.3. 6 жилийн хугацаагаар профессорын зэрэглэлд ажилласан байх
 - 3.5.4. Профессор цолд шаардагдах оноог бүрэн цуглуулсан байх ба үүнд дэд профессор цол авсан хугацаанаас хойших ажлыг тооцно.
- 3.6. МУИС-ийн дэд профессор цолд нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна:
 - 3.6.1. 5-аас доошгүй магистрант удирдаж хамгаалуулсан байх (удирдаж хамгаалуулсан 1 докторантыг 2 магистранттай дүйцүүлнэ). Байгалийн ухаан, инженер технологийн салбарын хувьд 3 магистрант удирдаж хамгаалуулж болох бөгөөд ийм нөхцөлд дэд профессорын эрдэм шинжилгээний оноог 2 дахин ба түүнээс дээш давуулан биелүүлсэн байх шаардлагатай.

- 3.6.2. 6 жилийн хугацаагаар дэд профессорын зэрэглэлд ажилласан байх
- 3.6.3. Дэд профессор цолын шаардагдах оноог бүрэн цуглуулсан байх
- 3.7. МУИС-ийн профессор, дэд профессор цолд нэр дэвшигч МУИС-д суралцагч докторант, магистрант удирдаж хамгаалуулсан байна.
- 3.8. МУИС-ийн ректор, проректор, захирал, бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирал, газар, алба, хэлтсийн даргын албан тушаалд ажилласан хугацааг өмнө ажиллаж байсан зэрэглэлийн дагуу профессор, дэд профессорын зэрэглэлд ажилласан жилийн хугацаанд тооцно. Эдгээр албан тушаалд ажиллаж буй профессор багш нь бусад профессор багшийн адил МУИС-ийн профессор, дэд профессор цолд тавигдах шаардлагын дагуу ажлаа үнэлүүлнэ. Профессор багш нарын хувьд энэ журам хэрэгжиж эхлэхээс өмнөх тухайн албан тушаалын зэрэглэлд ажиллаж байсан хугацааг үргэлжлүүлэн тооцно.
- 3.9. МУИС-ийн профессор, дэд профессорын цолын болзол хангасан профессор багшид Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр үнэмлэх олгоно.
- 3.10. МУИС-ийн профессор, дэд профессор цолтой профессор багшид холбогдох хууль тогтоомжид заасны дагуу цалингийн нэмэгдэл олгоно.
- 3.11. Профессор болон дэд профессор цолтой профессор багш нь МУИС-ийн ажлын нэгдсэн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу хуваарьт хугацаанд ажлаа үнэлүүлнэ.
- 3.12. Бусад их, дээд сургуулийн профессор, дэд профессор цолыг МУИС-д дүйцүүлэн тооцохгүй.
- 3.13. МУИС-ийн профессор, дэд профессорын цолын шалгаруулалттай холбоотой аливаа гомдлыг МУИС-ийн Эрдмийн зөвлөлд эрдэмтэн нарийн бичгийн даргаар уламжлан тавина. Эрдмийн цол, эндаумент сангийн төрөлжсөн хороо гомдлыг 30 хоногийн дотор шалгаж, үр дүнг Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 3.14. МУИС-ийн профессор, дэд профессорын цолын болзол, шаардлага хангаагүй профессор багшийг шалгаруулсан нь тогтоогдвол Эрдмийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн захирлын тушаалаар уг шийдвэрийг хүчингүй болгоно.

Хүснэгт 1. МУИС-ийн профессор, дэд профессор цолын шалгаруулалтад биелүүлбэл зохих оноо

Албан тушаал	Эрдэм шинжилгээ	Сургалт, нийгмийн үйлчилгээ	Нийт
Дэд профессор	1960	840	2800
Профессор	960	210	1170

Тайлбар: Хүснэгтэд үзүүлсэн харгалзах оноог бүрэн биелүүлнэ. Профессор цолын эрдэм шинжилгээ, сургалт, нийгмийн үйлчилгээний оноонд дэд профессор цол авсан хугацаанаас хойших ажлыг тооцно.

Хүснэгт 2. Эрдэм шинжилгээний үйл ажиллагааг тооцох онооны шатлал

Эрдэм шинжилгээний ажлын үзүүлэлт	Хэмжих нэгж	Оноо
Web of Science JCR импакт фактор, Scopus CiteScore бүхий мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл: Б.1.1.1 тухайн судалгааны салбарын дундаж болон түүнээс дээгүүр индекстэй эрдэм шинжилгээний сэтгүүл; Б.1.1.2 дунджаас доогуур индекстэй эрдэм шинжилгээний сэтгүүл; ¹	1 өгүүлэл	400 320
Олон улсын мэдээллийн сангийн бүртгэлд орсон мэргэжлийн холбоо, нийгэмлэг, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаас эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүл ¹	1 өгүүлэл	160
МУИС-д бүртгэлтэй сэтгүүлийн жагсаалтад орсон, англи хэлээр хэвлэгддэг, олон улсын редакцын зөвлөл бүхий дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүл ¹	1 өгүүлэл	120
МУИС-д бүртгэлтэй сэтгүүлийн жагсаалтад орсон, монгол, англи хэлээр холимог хэлбэрээр болон монгол хэлээр хэвлэгддэг, мэргэжлийн түвшинд хянагддаг дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүл ¹	1 өгүүлэл	80
Нэг зохиогчтой нэг сэдэвт бүтээл - Web of Science болон Scopus-д бүртгэлтэй хэвлэлийн газраар хэвлүүлсэн; - бусад олон улсын хэвлэлийн газраар хэвлүүлсэн; - монгол хэлээр хэвлүүлсэн.	1 х.х.	45 30 20
Нэг сэдэвт хамтын бүтээл ² : - Web of Science болон Scopus-д бүртгэлтэй хэвлэлийн газраар хэвлүүлсэн; - бусад олон улсын хэвлэлийн газраар хэвлүүлсэн; - монгол хэлээр хэвлүүлсэн.	1 х.х.	30 20 15
Edited book буюу эмхэтгэсэн хамтын бүтээл ² • Web of Science болон Scopus-д бүртгэлтэй хэвлэлийн газраар хэвлүүлсэн; • бусад олон улсын хэвлэлийн газраар хэвлүүлсэн; • монгол хэлээр хэвлүүлсэн		22.5 15 7.5

¹ Нэгдүгээр зохиогч, холбоо баригч зохиогчдод 1.0, чиглүүлэгч зохиогчид (last author) 0.8, бусад зохиогчид 0.5-аар үржүүлж тооцно.

² Судалгааны хамтарсан бүтээл нь зохиогчдын оролцоо хэвлэлийн хуудсаар тодорхойлно. Тодорхойлох боломжгүй бол бүх оролцогчдод тэнцүү хувааж тооцно.

Сурвалж бичгийн судалгаа, сурвалж бичгийн эрдэм шинжилгээний орчуулга	1 х.х.	6
Хэлний толь бичиг, нэвтэрхий толь бичиг ²	1 х.х.	4.5
Шинэ бүтээлийн патент: - гадаадад - дотоодод	1 бүтээл	320 120
Бүтээгдэхүүний загвар: • гадаадад • дотоодод	1 бүтээл	120 40
МУИС-ийн нэр дээр бүртгүүлсэн оюуны өмчөөс оруулсан роялти	1 сая төгрөг	30
МУИС-ийн бус санхүүжилттэй төсөл: МУИС-ийн дансаар оруулсан төслийн нийт санхүүжилтээс төлсөн төслийн шимтгэл	1 сая төгрөг	30
Web of Science, Scopus бүхий мэдээллийн санд бүртгэгдсэн эшлэлийн тоо (давхардуулж тооцохгүй)	1 эшлэл	1

Хүснэгт 3. Сургалтын үйл ажиллагааг тооцох онооны шатлал

Сургалт	Хэмжээ	Оноо
Бакалаврын түвшний хичээлийн хөтөлбөр боловсруулах болон сайжруулах ³	1 хичээл	20
Магистр, докторын хичээлийн хөтөлбөр боловсруулах болон сайжруулах ⁶	1 хичээл	35
БШУЯ, МУИС-ийн болон их, дээд сургуулийн консорциумын шилдэг багшийн шагнал авах	1 шагнал	50
Сурах бичиг ⁴ • гадаад хэлээр бичигдсэн; • монгол хэлээр бичигдсэн; • зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй орчуулгын сурах бичиг,	1 х.х.	15 12 7.5
Гарын авлага	1 х.х.	3
Удирдаж хамгаалуулсан бакалаврын оюутны тоо	1 оюутан	10
Удирдаж хамгаалуулсан магистрын тоо	1 магистрант	30
Удирдаж хамгаалуулсан докторын тоо	1 докторант	60
Гадаад оюутан болон тусгай хөтөлбөрөөр суралцагчийг удирдах	1 хөтөлбөр 1 гадаад оюутан	15 10
Цахим хичээл боловсруулах (online.num.edu.mn сайтад байршуулсан байх)	1 хичээл (1 Бц)	30
Дотоодын магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланг бичилцсэн бол	1 хөтөлбөр	20
Гадаадын магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланг бичилцсэн бол	1 хөтөлбөр	40
Шинэ сургалтын арга зүй туршиж нэвтрүүлсэн	1 арга зүй	20

³ Хичээлийн хөтөлбөр боловсруулах болон сайжруулах ажилд багаар ажилласан бол нийт оноог бүх оролцогчдод тэнцүү хуваана.

⁴ Сурах бичиг, орчуулгын бүтээл нь бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдмийн зөвлөлөөр зөвшөөрөгдсөн байх ба олон зохиогчтой тохиолдолд зохиогчдын оролцоо тодорхой бол харгалзах хэвлэлийн хуудсаар нь, хэрэв зохиогчдын оролцоо тодорхойгүй бол оноог бүх оролцогчдод тэнцүү хуваана.

Хүснэгт 4. Сургууль, нийгэмд үзүүлэх үйлчилгээг тооцох онооны шатлал

Сургууль, нийгэмд үзүүлэх үйлчилгээ	Хэмжээ	Оноо
МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий болон дэд хорооны гишүүнээр ажиллах	1 хичээлийн жил	20
МУИС-ийн Удирдах зөвлөл, Эрдмийн зөвлөл болон сургуулийн эрдмийн зөвлөлийн гишүүнээр ажиллах (давхардуулж тооцож болно.)	1 хичээлийн жил	10
Их сургуулийн болон бүрэлдэхүүн/салбар сургуулийн аль нэг хорооны гишүүнээр, их семинар удирдаж ажиллах	1 хичээлийн жил	20
Сургуулийн захирлын тушаалаар ажлын хэсэгт орж ажиллах, бусад үүрэгт ажил хийж гүйцэтгэх	1 удаа	20
Улсын хэмжээнд олимпиад, уралдаан тэмцээн зохион байгуулах, комисст ажиллах, сургалт семинар удирдах, оролцох	1 удаа	10
Эрдэм шинжилгээний хялбаршуулсан ба сурталчилгааны өгүүлэл хэвлүүлэх	1 удаа	10
Олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах ажлын хэсэгт ажиллах	1 удаа	25
Улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах ажлын хэсэгт ажиллах	1 удаа	15
Телевиз, радиогийн нэвтрүүлэгт оролцож, мэргэжлээ сурталчлах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх	1 удаа	10
МУИС-ийн төгсөгчдийн холбооны ажилд оролцох	1 хичээлийн жил	20
Мэргэжлийн холбоодын удирдах зөвлөлд болон гишүүнээр ажиллах	1 хичээлийн жил	15